



**СЭЛЭНГЭ АЙМАГ
ОРХОНТУУЛ СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2018 оны 10 сарын 18 өдөр

Дугаар 70

Баянцогт

Г Үндсэн чиглэл батлах тухай Г

Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын "а", Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.2, 16 дугаар зүйлийн 16.2 дахь заалтыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Орхонтуул сумын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хавсралтаар баталсугай.

2.Сумын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан бодлогын зорилтуудыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, сумын нийт иргэд, аж ахуй нэгж, байгууллагуудад сурталчлан таниулж, тэдний оролцоог ханган биелэлтийг гаргаж, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнан ажиллахыг сумын Засаг дарга /П.Батбаатар/-д үүрэг болгосугай.

ДАРГА  М.ЦОГБАЯР



Орхонтуул сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 70 тоот тогтоолын хавсралт



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ОРХОНТУУЛ СУМЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2019 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

№	д/д	Үндэслэсэн дунд хугацааны бодлогын баримт бичиг	Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт		Шаардагдах хөрөнгийн эх үүсвэр	Хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага
				Одоогийн байдал /суурь түвшин/	Хүрэх түвшин /2019 оны жилийн эцсийн байдлаар/			
НЭГ.ХӨГЖЛИЙН БОДЛОГО								
1.1.Хөдөө аж ахуйн бодлого								
Хөдөө аж ахуйг хөгжүүлж эрүүл, аюулгүй хүнсний хангамжийг нэмэгдүүлэх								
Газар тариалангийн чиглэлээр:								
1	1.1.1	СЗДУАХ-ийн 1.1.14	Тариалангийн талбайг хашаажуулалтыг 30 хувьд хүргэх	Сумын нийт 26,0 га эргэлтийн талбайгаас 1000 орчим га-г хашаажуулсан байна.	Сумын төвтэй ойр тариан талбайг хашаажуулж 30%-д хүргэсэн байна.	Тухайн аж ахуй нэгж өөрийн хөрөнгөөр	2,3-р улиралд	Хөдөө аж ахуйн тасаг Багийн Засаг дарга ААН байгууллагууд
2	1.1.2	СЗДУАХ-ийн 1.1.14	Тариалангийн талбайн тэлэлтийг тогтоож хариуцлага тооцох	Нийт тэлсэн талбайг хэмжээгүй, мэргэжлийн байгууллагын дэмжлэг туслалцаа шаардлагатай байна.	Ямар аж ахуй нэгж хэдэн га-гаар тэлсэн нь тодорхой болж хариуцлага хүлээлгэж хэрэгжилтийг хангасан байна.	Улсын төсвийн хөрөнгөөр	2,3,4-р улиралд	Газрын асуудал хариуцсан мэргэжилтэн Байгаль орчны хяналтын улсын байцаагч
3	1.1.3	СЗДУАХ-ийн 1.1.10	Газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэх гол түүхий эд болох ургамал хамгааллын бодис бордоог урьдчилгаатай	Үр ариутгах бодис захиалсан аж ахуй нэгж 18 аж ахуй нэгж 16 иргэн. Тиедутин-994,5тн Герицид- 5 ангиллан Алмазин-201,5тн	Тариалангийн түүхийн технологи сайжирна.	ААНБ-га өөрсдийн хөрөнгөөр	Жилдээ	Агрономч ААН-үүд

			бүтээгдэхүүнээрээ төлөх гэрээгээр нийлүүлэн хийх ААН-тэй хамтран ажиллах	Феназзин-257тн Зингер-59,5тн Фумасипер-59700тн Нийлмэл бордоог 499тн тус тус захиалсан байна.				
4	1.1.4	СЗДҮАХ-ийн 1.1.11	Газар тариалан, төмс, хүнсний ногоо эрхлэгчдийг техник, тоног төхөөрөмжөөр шинэчлэх төсөл хөтөлбөрт хамрагдахад нь дэмжлэг үзүүлж дээд шатны байгууллагад тавьж шийдвэрлүүлэх	Төмс хүнсний ногоо тариалагчид техник, тоног төхөөрөмжгүй гар ажиллагаатай байна.	Иргэн, ААНБ-ын техникийн парк сайжирна.	ААНБ-га өөрсдийн хөрөнгөөр	Жилдээ	Агрономч ААН-үүд
5	1.1.5	СЗДҮАХ-ийн 1.1.11	Ашиглалтгүй байгаа төмс, хүнсний ногооны талбайг эдийн засгийн эргэлтэнд оруулах	Ашиглагдахгүй байгаа нийт 55 га талбай байна.	Төмс, хүнсний ногооны тариалалт нэмэгдэж зах зээлийн үнээс хямд өртгөөр хэрэглэх боломж бүрдэнэ.	-	1-р улиралд	Газрын асуудал хариуцсан мэргэжилтэн Агрономич
6	1.1.6	СЗДҮАХ-ийн 1.1.12	“Зоорь” хөтөлбөр боловсруулж сумын ИТХ-н хурлаар батлуулан зоорийн аж ахуй эрхлэх хүсэлтэй иргэдийн санал санаачлагыг дэмжинэ.	Суманд томоохон зоорь байхгүй.	Зоорийн тоо нэмэгдэнэ.	Улс, Аймаг, сумын төсвийн хөрөнгө оруулалтаар	Жилдээ	Хөдөө аж ахуйн тасаг
7	1.1.7	СЗДҮАХ-ийн 1.1.13	Цахилгааны шугам татах боломжтой төмс, хүнсний ногооны талбай руу шугам тавих ажлыг холбогдох байгууллагуудад тавьж шийдвэрлүүлэх	Цахилгааны шугам татах боломжтой Баянцогт 2-р баг Цагаан эрэгт төмс, хүнсний ногооны талбай 25 га байгаа бөгөөд одоогоор бүрэн ашиглагдахгүй байна.	Төмс, хүнсний ногооны талбайг бүрэн ашиглах боломж бүрдэж дотоодын хэрэгцээгээ бүрэн хангана.	Улс, аймгийн хөрөнгө оруулалтаар	1,2-р улиралд	Газрын асуудал хариуцсан мэргэжилтэн Агрономич
8	1.1.8	СЗДҮАХ-ийн 1.1.16	“Худаг” хөтөлбөрийн төслийг боловсруулан сумын ИТХ-н хурлаар батлуулан Баянцогтын 2-р багийн айл өрхийг хашаандаа худагтай	Баянцогт 2-р багт хашаандаа худагтай 2 өрх байна.	Баянцогт 2-р багт хашаандаа худагтай өрхийн тоо нэмэгдэж төмс, хүнсний ногоо, жимсний мод бут	Аймгийн Засаг даргын дэмжлэгээр	Жилдээ	Газрын асуудал хариуцсан мэргэжилтэн

			болоход дэмжлэг үзүүлж өрх бүрийг төмс, хүнсний ногоо, жимсний мод тарьж ногоон байгууламжтай болоход дэмжлэг үзүүлж Амьдралын төгөл хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.		тарьж ургуулах боломжтой болно.			
Мал аж ахуйн талаар:								
9	1.1.9	СЗДҮАХ-ийн 1.1.15	Сумын өвс тэжээлийн аюулгүйн нөөцийг бүрдүүлж “Тэжээл” үйлдвэрлэх иргэдийг бодлогоор дэмжинэ.	2018 онд сумын “Аюулгүй нөөцөд” 50тн өвс, 10тн тэжээл бэлтгэнэ.	Фонд бүрдсэнээр өвөлжилт хүндэрсэн малчин болоод мал бүхий өрхөд туслах боломж бүрдсэн байна.	Бизнесийн хадлан эрхлэгч иргэд, тариалан эрхлэгч ААНБ-га, иргэнтэй хамтран	3-р улиралд	Газрын асуудал хариуцсан мэргэжилтэн
10	1.1.10	СЗДҮАХ-ийн 1.1.19	Мал угаалгын ванны тоо хүртээмжийг малын тоо, газрын байршлыг харгалзан нэмэгдүүлэх. Явуулын мал угаалгын ванныг судлан шийдвэрлэх.	Сумын хэмжээнд 3 мал угаалгын ванн, тарилгын хашаа байгаа нь сумын нийт 200 гаруй мянган толгой малыг бүрэн хамруулж хүчин чадал хүрэхгүйн дээр зарим малчид 50 гаруй км явж хамгийн ойрын мал угаалгын ванн-д хүрч малаа угаалганд хамруулах шаардлагатай болдог.	Тарилгын болон мал угаалгын хашаа 1-р нэмэгдсэн байна.	Нийгмийн хариуцлагын гэрээгээр	2,3-р улиралд	Багийн Засаг дарга нар
11	1.1.11	СЗДҮАХ-ийн 1.1.21	Малчдын намаржаа, зуслан, хаваржааны бүс нутгийг тогтоож мөрдүүлэх замаар бэлчээрийг зохистой ээлж сэлгээтэй ашиглах байдлыг хэвшүүлэх. Малчид болон мал бүхий иргэдтэй хариуцлагын гэрээ байгуулах.	Намаржаа, зуслан, хаваржааны бүсийг албан ёсоор тогтоож малчдад мэдээлээгүйгээс бэлчээрийг дур зоргоор ашиглах байдал давамгайлж байна.	Намаржаа, зуслан, хаваржааны бүсийг тогтоон баталж малчдад мэдээлсэн байна. Бэлчээрийг зүй зохистой ашиглах боломж бүрдсэн байна.	Сумын хөрөнгө оруулалтаар	Жилдээ	Газрын асуудал хариуцсан мэргэжилтэн Багийн Засаг дарга нар Хөдөө аж ахуйн тасаг

12	1.1.12	СЗДУАХ-ийн 1.1.1	Мал сүргийн эрүүл мэндийг хамгаалах ажлыг тогтмолжуулж, халдварт болон паразит өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилга, ариутгал халдваргүйжүүлэлтийг технологийн хугацаанд чанартай хийж гүйцэтгэх талаар Мал эмнэлэг үржлийн нэгжүүдэд тавих хяналтыг сайжруулж Мал эмнэлэг байгуулах иргэдийг бодлогоор дэмжинэ.	Мал эмнэлгийн байгууллагийн хүрэлцээ муу байгаагаас сумын мал сүрэг халдварт өвчинөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд бүрэн хамрагдаж чадахгүй байна.	Халдварт, паразитах өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамрагдах мал сүргийг бүрэн хамруулж малчдын өвөлжөө хашаанд ариутгал халдваргүйжүүлэлт хийгдсэн байна.	ААНБ-га,иргэн өөрсдийн хөрөнгөөр	Жилдээ	Мал үржлийн тасаг МЭҮН-үүд
13	1.1.13		“Ногоон алт” хөтөлбөрийг хэрэгжүүлж малчдыг бүлгийн зохион байгуулалтанд бүрэн хамруулна.	Одоогийн байдлаар малчдын 4 бүлэг байна.Үүнд Шар-ус 1-р багт 3,Хонгор овоо 3-р багт 1 бүлэг байгуулагдаад байна.	Хөтөлбөр хэрэгжиснээр бэлчээрийг зүй зохистой ашиглах,малчидын хамтын ажиллагаа сайжирна.	“Ногоон алт” хөтөлбөрөөс	Жилдээ	ХАА-н тасаг Газрын даамал Агрономич БЗДарга нар
14	1.1.14	СЗДУАХ-ийн 1.1.1	Бусад аймаг сумаас мал оруулахыг хориглосон шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллах	Энэ оны 9 сарын байдлаар зохих зөвшөөрөлгүй Сэлэнгэ аймгийн Орхон сумын 5 малчин өрх, Завхан аймгийн Дөрвөлжин сумын 2 малчин өрх, Увс аймгийн Тэс сумын 2 малчин өрх тус тус ирсэн байсныг албадан нүүлгэх талаар хугацаатай мэдэгдэл өгч хэрэгжилтийг хангуулан ажиллалаа.	Малын тооны механик өсөлтийг хязгаарлана.	Сумын хөрөнгө оруулалтаар	Жилдээ	Багийн Засаг дарга нар Мал үржлийн тасаг
15	1.1.15	СЗДУАХ-ийн 2.1.17	Бэлчээрт хөнөөл учруулдаг хортон, мэрэгчтэй байгаль орчинд халгүй дэвшилтэт аргаар устгал хийх ажлыг 5000 га-д хийх	Бэлчээр хадлангийн талбайд тархсан хортон мэрэгчийн тоо толгой ихэсч тархсан талбайн хэмжээ нэмэгдсэн.	Бэлчээр хадлангийн ургац нэмэгдэж, 5000 га бэлчээрийн хортон мэрэгчийн тоо цөөрнө.	Аймгийн хөрөнгө оруулалтаар	2-р улиралд	ХАА тасаг

1.2.Байгаль орчны бодлого

Байгаль орчныг хамгаалах талаар гарсан Монгол улсын хуулиудын хэрэгжилтийг зохион байгуулж хариуцлагатай уул уурхай хөгжүүлнэ.

16	1.2.1	СЗДҮАХ-ийн 1.2.1	“Бичил уурхайн сумын хөтөлбөр”-ийн төслийг хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж сумын ИТХ-н хурлаар хэлэлцүүлэх	120 гаруй гишүүнтэй Орхонтуулын хишиг төрийн бус байгуулагдсан. Үүнээс 2 нөхөрлөл нь 2018 онд сумын Засаг даргатай хамтран ажиллах гэрээ байгуулсан. Бичил уурхайгаар нөхөн сэргээсэн газрын хэмжээ тодорхойгүй.	Бичил уурхай эрхлэгчид зохион байгуулалтанд орж үйл ажиллагаа нь хууль журамд нийцнэ.	Сумын хөрөнгө оруулалтаар	Жилдээ	Байгаль орчны алба
17	1.2.2	СЗДҮАХ-ийн 1.2.2	Халтар ишигний рашаанд мэргэжлийн байгууллагаар шинжилгээ дүгнэлт гаргуулах	Мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулаагүй.	Рашааны эмчилгээний чиглэл буюу ямар өвчнийг анагаахад сайн болох нь тодорхой болно.	Сумын хөрөнгө оруулалтаар	2-р улиралд	Байгаль орчны алба
18	1.2.3	СЗДҮАХ-ийн 1.2.5	Сум, тосгоны төвийн хогийн төвлөрсөн цэгийг шинээр байгуулан тохижуулах	Сум, тосгоны төвийн хогийн төвлөрсөн цэг нь олон жил ашигласнаас даац нь хэтэрч ундны ус руу урсч орох, илт задгай хийсч хөрсний бохирдол үүсгэх нөхцөл бүрдсэн.	Хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилт хангагдана.	Нийгмийн хариуцлагын гэрээгээр	2-р улиралд	Байгаль орчны алба
19	1.2.4	СЗДҮАХ-	Байгаль орчны тухай хууль, журмуудын хэрэгжилтэнд хяналт тавьж, илэрсэн зөрчил, дутагдлыг бүрэн арилгах үүднээс байгаль орчны багц хуулийн хүрээнд жилд 3 удаа сургалт зохион байгуулах, төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг улиралд 1 удаа хийх	Зөвшөөрөлгүй уул уурхайн олборлолтын үйл ажиллагаа нэмэгдэж хууль бус ан агнуурын хэрэг гарсан.	Байгаль орчны багц хууль, 70 орчим журмын хэрэгжилт хангагдана	Төсөл хөтөлбөр Сумын хөрөнгө оруулалтаар	Жилдээ	Байгаль орчны алба
20	1.2.5	СЗДҮАХ-ийн 1.2.3, 1.2.7	Баруунбүрэн сумтай хэрэглээний түлээ бэлтгэх	Энэ онд Баруунбүрэн сумтай хэрэглээний зориулалтаар 500	Хуулийн хэрэгжилт хангагдана.	-	Жилдээ	Байгаль орчны алба

			гэрээ байгуулан хэрэгжилтэнд хяналт тавих	куб, түлээний зориулалтаар 1500 куб модны гэрээ хийгдсэн байна.				
21	1.2.6	СЗДҮАХ-ийн 3.1.16	Сумын нутаг дэвсгэрт хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж байгууллагуудтай Нийгмийн хариуцлагын гэрээ байгуулан хяналт тавьж, тэдгээрийн мэдээллийн санг бүрдүүлж, гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавьж ажиллах	Манай суманд 36 компанид нийт 45 тусгай зөвшөөрөл олгогдсон байдаг байна.	Нийгмийн хариуцлагын гэрээний хэрэгжилт хангагдана.	-	2-р улиралд	Байгаль орчны алба
22	1.2.7	СЗДҮАХ-ийн 1.2.1	Хөрс хамгаалах, газрын доройтлыг бууруулах бодлого хэрэгжүүлж уул уурхайн хайгуул, олборлолтонд өртөж эвдрэлд орсон газруудыг нөхөн сэргээж холбогдох хуулийг хэрэгжилтийг хангуулах	Нөхөн сэргээх шаардлагатай талбайн хэмжээ байна.	Нөхөн сэргээлт хийгдсэн хэмжээ байна. талбайн нэмэгдсэн	ААНБ-га, бүлэг хоршоо, иргэн өөрсдийн хөрөнгөөр	Жилдээ	Байгаль орчны алба
23	1.2.8	СЗДҮАХ	Иргэнд өмчлүүлэх газрын хэмжээ байршлыг тогтоон иргэдийн хурлаар батлуулж, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлж, төлөвлөгдсөн газраас иргэдийн сонголтоор өмчлүүлэх арга хэмжээг эрчимжүүлнэ.	2018 оны сумын ГЗБ-ын төлөвлөгөөнд 150 иргэнд 111,257м2 өмчлүүлэхээр тусгаснаас 150 иргэнд газар өмчлүүлэх сумын Засаг даргын захирамж гарч 121 иргэн кадастр хийлгэн эд хөрөнгийн гэрчилгээ гаргуулан авсан байна.	Ирэх онд олгогдох хэмжээг төлөвлөн батлуулж хэрэгжилтийг хангуулна.	-	Жилдээ	Газрын асуудал хариуцсан мэргэжилтэн
24	1.2.9		Хадлангийн газрын төлбөр хураамжийг шинэчлэн тогтоолгож, эзэмшүүлэх асуудлыг зохицуулах сумын	Орон нутгийн иргэд өөрсдийн нэр дээр гэрээ хийж бусад аймаг, сумын иргэдэд хадлангийн газар авч өгч	Зөвхөн сумын иргэд төлөвлөсөн газруудад ахуйн болон бизнесийн хадлангаа	-	1-2 улиралд	Газрын асуудал хариуцсан мэргэжилтэн

			журмын төслийг боловсруулан ИТХ-н хурлаар хэлэлцүүлэх	байгаа нь маргаантай байдлыг үүсгэж байна.	хийж Газрын тухай хуулийн хэрэгжилт хангагдаж сум өөрийн баримтлах журамтай болсон байна.			
25	1.2.10	СЗДҮАХ-ийн 1.2.5	Хөрс, усны бохирдлын шинжилгээг жил бүр мэргэжлийн байгууллагаар хийлгэж хог хаягдлын зохистой менежментийг хэрэгжүүлнэ.	Хөрс, усны бохирдлын шинжилгээг хийлгээгүй.	Хөрс, усны бохирдлын шинжилгээг хийлгэж иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах хуулийн заалт хэрэгжинэ.	Орон нутгийн төсвөөс	2-р улиралд	Байгаль орчны алба
26	1.2.11	СЗДҮАХ-ийн 1.2.6.	Сумын хэмжээнд түлээ нүүрсний зах бий болгож иргэдээ дэмжиж ажиллана.	Түлээ, нүүрсний зах, худалдан борлуулдаг цэг байхгүй.	Иргэд ойроос түлээ нүүрсээ авах боломжтой болж эдийн засагт хэмнэлт гарна.	Санаачилга гаргасан иргэн, аж ахуй нэгж өөрийн хөрөнгөөр	2-р улиралд	Байгаль орчны алба

1.3. Дэд бүтцийн бодлого:

Дэд бүтцийн салбарын хүрсэн түвшинг бататгаж, улсын болон орон нутгийн төсөв, иргэн аж ахуйн нэгжийн болон гадаад дотоодын зээл тусламжийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх

27	1.3.1	СЗДҮЭХ-ийн 1.4.1	Ерөнхий боловсролын 1,2-р сургуулийн барилгыг их засварт оруулах хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэх	Ашиглалтанд орсоноос хойш их засварт ороогүй.	Хичээлийн барилгыг бүхэлд нь ашигладаг болно.	Улсын төсвийн хөрөнгөөр	Жилдээ	Сумын Засаг дарга ЕБ2-р сургуулийн захирал
28	1.3.2	СЗДҮАХ-ийн 1.4.3	Рашаант тосгонд хүүхдийн барилгын асуудлыг холбогдох байгууллагад нь тавьж шийдвэрлүүлэх	Рашаант тосгонд цэцэрлэгийн насны 159 хүүхэд байна. Үүнээс Төмөр замын "Орхон" цэцэрлэг-60 хүүхэд, 24-р цэцэрлэгийн салбар "Бүжинхэн" цэцэрлэгт 56 хүүхэд нийт 116 хүүхэд СӨБ-д хамрагддаг байна.	Цэцэрлэг ашиглалтанд орж үйл ажиллагаа нь эхэлсэнээр нэг ангид байх хүүхдийн стандарт хангагдаж СӨБ-н хамрагдалт сумын хэмжээнд 100%-д хүрнэ.	Улсын төсвийн хөрөнгөөр	Жилдээ	Засаг дарга
29	1.3.3	СЗДҮАХ-ийн 1.4.10	Гэр хорооллын айл өрхүүдэд стандартын шаардлагад нийцсэн бие засах газар, хашаа, хаягжуулалтыг шинэчлэн	Стандартын шаардлагад нийцүүлж хаягжуулалтыг шинээр хийх шаардлагатай.	Иргэдийн амьдрах орчин нөхцөл сайжирна.	ОНХсангаар	2,3-р улиралд	Багийн Засаг дарга нар

			“Жишиг хороолол” бий болгоно					
30	1.3.4	СЗДҮАХ-н 1.4.7	Усан санг харуул хамгаалалттай болгоход шаардлагатай хөрөнгө оруулалтыг шийдвэрлүүлэх	Усан сангийн хашаажуулалтын 1,5 сая төгрөгийг энэ онд баталсан. Байнгын харуул байхгүй.	Усан сан байнгын харуултай болсон байна.		2,3-р улиралд	Сумын Засаг дарга “Туулын хишиг” ОНӨААТҮГ-н дарга
31	1.3.5	СЗДҮАХ-нийн 1.4.8	Цэвэрлэх байгууламжтай болох асуудлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх	Цэвэрлэх байгууламж байхгүй	Цэвэрлэх байгууламжийн хөрөнгийн асуудал шийдвэрлэгдсэн байна.	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар	Жилдээ	Сумын Засаг дарга “Туулын хишиг” ОНӨААТҮГ-н дарга
32	1.3.6	СЗДҮАХ-ийн 1.4.12	Рашаант тосгоны Соёлын төв, Захирагчийн ажлын албаны байрыг ашиглалтанд оруулж, тоног төхөөрөмжөөр хангана.	Барилгын ажил дуусаагүй.	Иргэд төрийн үйлчилгээг ойроос авч урлаг соёлын арга хэмжээнд тогтмол хамрагдана.	Улсын төсвийн хөрөнгөөр	Жилдээ	Рашаант тосгоны Захирагч, СЗДТГ-н дарга
33	1.3.7	СЗДҮАХ-ийн 1.4.15	Сумын төвийн төв замыг сайжруулан засварлан сайжруулж, орон нутгийн чанартай замын тэмдэг тэмдэглэгээтэй болох	Төв замыг сайжруулж засварлах шаардлагатай ба орон нутгийн чанартай замуудад тэмдэг тэмдэглэгээ хангалтгүй байна.	Замын хөдөлгөөний аюулгүй байдал сайжирч аюулгүй орчин бүрдсэн байна.	Нийгмийн хариуцлагын гэрээгээр	2,3-р улиралд	Засаг даргын орлогч, Багийн Засаг дарга нар
34	1.3.8		Атрын 60 жилийн ой тохиохтой холбогдуулан газар тариалан эрхлэгчдийг алдаршуулсан “Хүндэтгэлийн талбай”-г сумын төвд байгуулж, авто машины зогсоол байгуулах	Өнөөгийн байдлаар тариаланчдаа алдаршуулсан танхим, цэцэрлэгт хүрээлэн байхгүй байна.	Атрын анхдагчууд болон үе үеийн тариаланчдын алдрыг мөнхөлсөн “Хүндэтгэлийн талбай”-тай болсон байна.	Нийгмийн хариуцлагын гэрээгээр	Жилдээ	Засаг даргын орлогч, ХАА-н тасаг, Тариаланчдын зөвлөл
35	1.3.9	СЗДҮХ-ийн 1.4.15	Сум, тосгоны төвийн гэрэлтүүлгийн тоог нэмэгдүүлэх	Баянцогт 2-р багт 54 гэрэлтүүлэг байгаагаас 28 гэрэл асахгүй засварлах шаардлагатай, Рашаант тосгонд 47 гэрэл байгаагаас 11 гэрэл асахгүй засварлах шаардлагатай.	Гэрэлтүүлэг бүрэн засварлагдсан байна.	Аймгийн замын сангийн хөрөнгөөр	3-р улиралд	Багийн Засаг дарга нар

36	1.3.10	СЗДҮХ-ийн 1.4.12	Сумын төвд ашиглагдахгүй байгаа орон сууцыг эзэмшиж байгаа иргэдтэй тохиролцон засварлаж ашиглалтанд оруулж, сумын өнгө үзэмж тохижилтын ажлыг нэмэгдүүлнэ.	Иргэд өмчилсөн боловч ашиглагдахгүй байгаа 30 гаруй айлын байр байгаа.	Сумын өнгө үзэмж сайжирч шинэ залуу гэр бүлүүд орон нутагтаа ажиллаж амьдрах боломжид сайнаар нөлөөлнө.	Тухайн иргэн, аж ахуй нэгж өөрийн хөрөнгөөр	Жилдээ	Засаг даргын орлогч
37	1.3.11	СЗДҮАХ-ийн 1.4.18	Цагдаагийн кабоныг бүрэн засварлаж Хэсгийн төлөөлөгч, цагдаа нарын амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлнэ.	Цагдаагийн кабоны барилга нь цууралт өгч цаашид ашиглах боломжгүй гэсэн дүгнэлт гарсан.	Цагдаагийн албан хаагчдын ажиллаж, амьдрах орчин нөхцөл сайжирна.	Аймаг, сумын хөрөнгөөр	Жилдээ	Засаг даргын орлогч
38	1.3.12	СЗДҮАХ-ийн 1.1.18	Золбин нохой устгалын ажлыг жилд 1-2 удаа зохион байгуулна.	Золбин нохой устгалын ажлыг жилд 1-2 удаа заавал хийх шаардлагатай байдаг.	Иргэд эрүүл аюулгүй орчин нөхцөлд амьдарна.	Сумын хөрөнгөөр	1,4-р улиралд	Багийн Засаг дарга нар
39	1.3.13	СЗДҮАХ-ийн 1.4.19	Сумын төвийн орон сууцнуудыг хэрэглээний халуун усаар хангах талаар Халаалтын төвд шаардлагатай байгаа тоног төхөөрөмжийг шинэчилнэ.	Сумын төвийн орон сууцны 72 өрхөд хэрэглээний тоолуур болон дотоод холболтыг хийх шаарлагатай байна.	Орон сууцанд оршин суудаг иргэдийн ая тухтай орчин нөхцөлд амьдрах боломж бүрдэнэ.	Аймгийн Засаг даргын дэмжлэг болон төсөл хөтөлбөрөөр.	Жилдээ	“Туулын хишиг” ОНӨААТҮГ-н дарга Сумын Засаг дарга
40	1.3.14	СЗДҮАХ-ийн 1.4.20	Гэр хорооллуудыг худаг уст цэгт ухаалаг технологийг нэвтрүүлнэ.	Баянцогт 2-р багийн Туулын дэнж хорооллын үндны усны цэгт ухаалаг технологийг нэвтрүүлсэн нь иргэдийн сэтгэлд маш их нийцсэн байна.	Иргэд цагийн хязгаарлалтгүй усаа авах боломжтой болно.	ОНХсангаар	2-р улиралд	Засаг даргын орлогч
41	1.3.15	СЗДҮАХ-ийн 1.4.24	Иргэнээ эрүүл таатай цэвэр орчинд амьдрах амрах идэвхийг өрнүүлэх зорилгоор сумын “Соёлч өрх” журмыг хэрэгжүүлэн шинэ жилийн баярын үйл ажиллагаан дээр шагналыг нь гардуулж өрх иргэнээ дэмжиж ажиллана.	Соёлч өрх журмыг хэрэгжүүлж эхэлсэнээр иргэд хамтран амьдарч байгаа орчин нөхцөлөө сайжруулах тал дээр эерэг өөрчлөлт гарч сум, тосгоны төвийн орон сууцанд амьдардаг иргэд хамтран орцоо засварлаж тохижуулсан.	Иргэдийн амьдрах нөхцөл сайжирна.	Засаг даргын нөөц хөрөнгөөр	Жилдээ	Нийгмийн бодлого хариуцсан мэргэжилтэн

1.4.Худалдаа үйлчилгээний чиглэлээр:

Худалдааны байгууллагаас ард иргэдийг эрүүл хүнсээр хангах,иргэдэд соёлч боловсон үйлчилж байгаа эсэхэд хяналт тавьж, ахуйн үйлчилгээг нэмэгдүүлэх бодлого барьж ажиллана.

42	1.4.1	СЗДҮАХ-ийн 1.3.1	Сум, тосгоны төвд үсчин, халуун ус, гутал засварын үйлчилгээ эрхлэх хүсэлтэй иргэдийг бодлогоор дэмжинэ.	Рашаант тосгонд үсчин, халуун ус тогтмол ажиллаж байна. Гутал засварын үйлчилгээ сум, тосгоны төвийн алинд нь ч байхгүй мөн сумын төвд үсчин, халуун ус байхгүй.	Үсчин, халуун ус, гутал засварын үйлчилгээтэй болсон байна.	Хөдөлмөр эрхлэлтийн төсөл хөтөлбөр болон ОНХсан, Сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөр	Жилдээ	Хөдөлмөр эрхлэлт хариуцсан мэргэжилтэн
43	1.4.2	СЗДҮАХ 1.3.2	Худалдаа, үйлчилгээний салбарын үйлчилгээний чанар, боловсон хүчний чадавхийг сайжруулж, үйлчилгээний соёл, стандарт, эрх үүргийн тухай мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлэх чиглэлээр сургалтын үйл ажиллагаанд хамруулах.	Худалдаа үйлчилгээний эрүү ахуйн стандарт бүрэн хангагдаж чадаагүй байна.	Худалдаа үйлчилгээний салбарын үйлчилгээний болон орчин нөхцөл сайжирч холбогдох хууль журмын хэрэгжилт хангагдана.	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрөөр	Жилдээ	Хөдөлмөр эрхлэлт хариуцсан мэргэжилтэн
44	1.4.3	СЗДҮАХ-ийн 1.3.4	“Худалдаа үйлчилгээ эрхлэгчийн зөвлөл”-ийг байгуулж ажиллана.	Зөвлөл байгуулагдаагүй байна.	Худалдаа үйлчилгээ эрхлэгчдийн зөвлөлтэй болж төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа сайжирна.	Орон нутгийн хөрөнгөөр	1-р улиралд	Хөдөлмөр эрхлэлт хариуцсан мэргэжилтэн

1.5. Төсөв санхүү, хөрөнгө оруулалтын чиглэлээр:

Төсвийн зардлыг хэмнэлттэй зарцуулах, шилэн дансны ил тод байдлыг хангаж суманд ирж буй төсөл хөтөлбөрүүдийг нээлттэй болгож иргэдийн үнэт цаасны зах зээлийн мэдлэгийг дээшлүүлнэ.

45	1.5.1	СЗДҮАХ-ийн 1.5.1	Орон нутгийн хөгжлийн сан, сум хөгжүүлэх сангийн хөрөнгө болон суманд ирж буй аливаа төсөл, хөтөлбөрүүдийг иргэдэд нээлттэй мэдээлж, иргэдийн саналд тулгуурлан үр нөлөөтэй зарцуулан хэрэгжилтэнд нь тэдний хяналт тавих	Төсвийн мэдээллийг сумын сайт, фэсебоок хуудас, мэдээллийн самбараар иргэдэд мэдээлж байна.	Төсөв санхүүгийн зөрчилгүй сум болно.	-	Жилдээ	Санхүүгийн алба Хөдөлмөр эрхлэлт хариуцсан мэргэжилтэн
----	-------	---------------------	---	---	---------------------------------------	---	--------	--

			оролцоог нэмэгдүүлэн мэдээллийн сан бүрдүүлж ажиллана.					
46	1.5.2	СЗДҮАХ-ийн 1.5.1	Сум хөгжүүлэх сангаас олгох зээлийн эргэн төлөлтийг сайжруулна.	Одоогийн байдлаар сум хөгжүүлэх сангаас зээл аваад эргэн төлөлтөө хийгээгүй иргэдтэй шүүхийн шийдвэрийн дагуу эвлэрлийн гэрээ байгуулан гэрээний дагуу төлөөгүй иргэдээс албадан гаргуулах арга хэмжээ авагдахаар байна.	Зээлийн эргэн төлөлт сайжирч дараагийн зээлдэгч зээл гарах нөхцөл бүрдэнэ.	-	Жилдээ	Хөдөлмөр эрхлэлт хариуцсан мэргэжилтэн
47	1.5.3	СЗДҮАХ-ийн 1.5.2	Татвар төлөгчдийг татварын хуулийг сайн дураараа дагаж мөрдөх дадалд хэвшүүлэх тэдний татварын боловсролыг дээшлүүлэх ажлыг зохион байгуулна.	Татварыг сайн дураараа төлөх дадал хэвшүүлэх ажил хангалтгүй.	Татварын бааз суурь нэмэгдэнэ.	-	Жилдээ	Татвар хураагч
48	1.5.4	СЗДҮАХ-ийн 1.5.6	Төсвийн зардлыг хэмнэлттэй зарцуулж, ил тод нээлттэй байдлыг ханган сахилга хариуцлагыг дээшлүүлж санхүүгийн дотоод хяналтыг сайжруулж төсөв, санхүүгийн зөрчилгүй сум болж ажиллана.	Төсвийн сахилга хариуцлага хангалтгүй.	Төсвийн хариуцлагатай, зохистой удирдлагыг хэрэгжүүлэх, ил тод байдлыг хангасан байх зэрэг зарчим бүрэн утгаараа хэрэгжинэ.	-	Жилдээ	Санхүүгийн алба
ХОЁР. ХҮН АМЫН ХӨГЖИЛ - НИЙГМИЙН БОДЛОГО								
2.1. Эрүүл мэндийн чиглэлээр:								
Эрүүл мэндийн салбарын ажилтнуудыг чадавхижуулж, иргэн бүрийг урьдчилан сэргийлэх үзлэг тандалтанд хамруулж халдварт болон халдварт бус өвчлөлийг бууруулна.								
49	2.1.1	СЗДҮАХ-ийн 2.1.2	“Эх хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж эх, нялхсын эндэгдэлгүй ажиллана.	Эх нялхасын эндэгдэлгүй ажиллаж байна.	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үйлчилгээ чанаржиж өвчлөл буурна.	Тухай байгууллага өөрийн хөрөнгөөр	Жилдээ	Эрүүл мэндийн төвүүд

50	2.1.2	СЗДУАХ-ийн 2.1.4	Хүний дархлал хомсдлын вирус, дархлалын олдмол хомсдол, бэлгийн замаар дамжих халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлнэ.	Бэлгийн замын халдварт өвчин буурсан.	Хүн амын дундах эрүүл мэндийн боловсрол нэмэгдэнэ.	Тухай байгууллага өөрийн хөрөнгөөр	Жилдээ	Эрүүл мэндийн төвүүд
51	2.1.3	СЗДУАХ-ийн 2.1.5	Амьсгалын замаар дамжих халдварт өвчин, улаан бурхан, улаанууд өвчний дархлаажуулалтын хамрагдалтыг сайжруулж өвчлөлийг бууруулах цогц арга хэмжээ авна.	Дархлаажуулалт 100%-тай.	Өвчлөл буурна.	Тухай байгууллага өөрийн хөрөнгөөр	Жилдээ	Эрүүл мэндийн төвүүд
52	2.1.4	СЗДУАХ-ийн 2.1.6	Сүрьеэгийн өвчлөлийг бууруулж урьдчилан сэргийлэх мэдээлэл сурталчилгаа, үзлэг тандалтын ажлыг эрчимжүүлнэ.	Шар-Ус 1-р баг, Рашаант тосгонд шинэ-1, дахин-1 сүрьеэгийн тохиолдол гарч эмнэлгийн хяналтанд эмчилгээгээ хийлгэж байна.	Сүрьеэгүй Сэлэнгэ хөтөлбөрийн хэрэгжилт хангагдана.	Тухай байгууллага өөрийн хөрөнгөөр	Жилдээ	Эрүүл мэндийн төвүүд
53	2.1.5	СЗДУАХ-ийн 2.1.8	Иргэн бүрийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх эрт илрүүлгийн үзлэгт хамруулахад явуулын амбалотори ашиглан үзлэг шинжилгээг хийх ажлыг зохион байгуулах цусны анализатортой болох.	Иргэдийн эрүүл мэндийн боловсрол хангалтгүйгээс өвчлөл ихэсч байна.	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үйлчилгээ чанаржиж өвчлөл буурна.	Тухай байгууллага өөрийн хөрөнгөөр Аймгийн хөрөнгө оруулалтаар	Жилдээ	Эрүүл мэндийн төвүүд Сумын засаг дарга
54	2.1.6	СЗДУАХ-ийн 1.3.4	Ахмад настан, 0-3 насны хүүхдийн гэрийн эргэлтийг тогтмолжуулан алслагдсан малчин айл, өрхөд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлж хүн амын эрүүл мэндийн сан бүрдүүлнэ.	Алслагдсан малчин өрхийн ахмад настан, 0-3 настай хүүхдийг дархлаажуулалтын ажлын хүрээнд сард 1 удаа эргэлт хийж хэвшсэн.	Алслагдсан багийн хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээ нэмэгдсэн байна.	Тухай байгууллага өөрийн хөрөнгөөр	Улирал тутам	Эрүүл мэндийн төвүүд

55	2.1.7	СЗДҮАХ-ийн 2.1.10	Төр, төсвийн байгууллагын албан хаагчдыг жилд нэг удаа эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулна.	Жилд 1 удаа эрүүл мэндийн үзлэгт орж чаддаггүй.	Өвчлөл буурч эрт илрүүлгийн хувь өснө.	Тухай байгууллага өөрийн хөрөнгөөр	Жилдээ	Эрүүл мэндийн төвүүд
56	2.1.8	СЗДҮАХ-ийн 2.1.11	Эмч, эмнэлгийн мэргэжилтний мэргэшил, үр чадварыг нь дээшлүүлэх, эрүүл мэндийн салбарын ажилтны ёс зүй, хариуцлагыг сайжруулж үр дүнг тооцон ажиллана.	Эрүүл мэндийн төвийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд нь аймаг, бүсээс зохион байгуулагдсан болон дотоодын сургалтанд хамрагдсан байна.	Эрүүл мэндийн үйлчилгээний чанар хүртээмж нэмэгдэнэ.	Тухай байгууллага өөрийн хөрөнгөөр	Жилдээ	Эрүүл мэндийн төвүүд
57	2.1.9	СЗДҮАХ-ийн 2.1.15	Сумын Эрүүл мэндийн төвийн “Эхийн амаржих байр”, Хүлээн авах, яаралтай тусламжийн өрөө, Чийрэгжүүлэлтийн өрөө, лабораторийн өрөөг тоног төхөөрөмжөөр хангаж тохижуулна.	Тоног төхөөрөмжөөр хангах шаардлагатай.	Эрүүл мэндийн үйлчилгээний чанар дээшилсэн байна.	Яам, аймгийн хөрөнгөөр	Жилдээ	Эрүүл мэндийн төвүүд

2.2. Боловсролын чиглэлээр:

Боловсролын салбарт ажиллагсадыг чадавхжуулж, сурч боловсрох, хөгжих, ажиллах, эрүүл аюулгүй ээлтэй орчныг бүрдүүлж боловсролын үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэнэ.

58	2.2.1	СЗДҮАХ-ийн 2.2.1, 2.2.3	24-р цэцэрлэгийн сургалтын хэрэглэгдэхүүнийг стандартад нийцүүлэн шинэчлэх талаар дээд шатны байгууллагад санал тавьж шийдвэрлүүлнэ.	MNS стандартад нийцсэн дуу хөгжмийн өрөө, биеийн тамирын болон гадаа талбайн тоглоомжуулалт байхгүй.	Стандартад нийцсэн хүүхэд хөгжүүлэх сургалтын хэрэглэгдэхүүнтэй болсон байна.	Тухайн байгууллагын төсвөөс	Жилдээ	24-р цэцэрлэгийн эрхлэгч
59	2.2.2	СЗДҮАХ-ийн 2.2.2	Малчдын хүүхдүүдийг сургуулийн өмнөх боловсролд хамрагдалтыг нэмэгдүүлж, Зуны цэцэрлэг, Гэр цэцэрлэг ажиллуулна.	Жил бүр малчид төвлөрсөн 1-2 газар Гэр цэцэрлэг ажиллуулж малчдын 25-35 хүүхдийг хамруулдаг.	СӨБ-ийн хамран сургалт 95%-д хүрнэ.	Тухайн байгууллагын төсвөөс	Жилдээ	24-р цэцэрлэгийн эрхлэгч
60	2.2.3	СЗДҮАХ-ийн 2.2.9	Хүүхдэд эх оронч үзэл санааг төлөвшүүлж, хүүхдийг гэмт хэрэг	Насанд хүрээгүй 1-2 иргэн холбогдсон гэмт хэрэг гардаг.	Хүүхэд зөв хүмүүжил төлөвшил олж гэмт	Тухайн байгууллагын төсвөөс	Жилдээ	ЕБ1,2-р сургууль, Хүүхэд хөгжлийн төв,

			зөрчлөөс урьдчилан сэргийлэх хүмүүжлийн олон талт ажлыг зохион байгуулна.		хэрэг зөрчилд холбогдохгүй.			ГХУСЗөвлөл
61	2.2.4	СЗДҮАХ-ийн 2.2.4	Ерөнхий боловсролын сургуулиудад стандартын шаардлага хангасан кабинетуудыг байгуулна.	Кабинетуудыг тохижуулж сургалтын хэрэглэгдэхүүнийг сайжруулах шаардлагатай.	Сургалтын чанар дээшилсэн байна.	Төсөл хөтөлбөрөөр	Жилдээ	ЕБ1,2-р сургууль
62	2.2.5	СЗДҮАХ-ийн 2.2.5	Үдийн цай болон Дотуур байр, цэцэрлэгүүдэд хэрэглэгдэх хүнсний бүтээгдэхүүний чанарт тавих хяналтыг сайжруулж, бүх сургууль, цэцэрлэгийг “Эрүүл мэндийг дэмжигч” сургууль, цэцэрлэг болох хөдөлгөөнд хамруулж, үр дүнг тооцно.	Үдийн цай болон дотуур байр, цэцэрлэгийн хоол хүнсний материалыг суманд үйл ажиллагаа явуулж байгаа хүнсний дэлгүүрүүдээс нийлүүлж байна.	Хүнсний аюулгүй байдал эрүүл ахуйн стандарт хангагдана.	Тухайн байгууллагын төсвөөс	Жилдээ	ЕБ1,2-р сургууль 24-р цэцэрлэг.
63	2.2.6	СЗДҮАХ-ийн 2.2.6	Сонгон, секц, дугуйлангаар хүүхдийн авьяас чадварыг нээн хөгжүүлж, төлөвшүүлэх үйлсийг санаачилсан, амжилт гаргасан багш, иргэн, байгууллагыг хөхүүлэн дэмжинэ.	2017-2018 оны хичээлийн жилд 1-р сургууль дээр 5 төрлийн секц, дугуйланд давхардсан тоогоор 175 хүүхэд хамрагдаж сурагчдын 64.8% нь өөрийгөө хөгжүүлэх дугуйлан, секцэнд, 2-р сургууль дээр 7 төрлийн секц, дугуйланд давхардсан тоогоор 173 сурагч хамрагдсан байна.	Хүүхдийг бүх талаар өв тэгш хөгжүүлэх боломжийг бүрдэнэ.	Байгууллага өөрийн төсвөөс Хөтөлбөрөөс.	Жилдээ	ЕБ1,2-р сургууль, Хүүхэд хөгжлийн төв
64	2.2.7	СЗДҮАХ-ийн 2.2.8	Сургалтын чанарыг сайжруулан багш нарыг чадавхжуулна.	Багш нар тогтмол шинээр суралцаж мэдлэг чадвараа нэмэгдүүлэх боломжтой.	Багш нарыг чадавхижуулсанаар сургалтын чанар сайжирч сурагчдын сурлагын чанар дээшилж амжилт гаргана.	Тухайн байгууллагын төсвөөс	Жилдээ	ЕБ1,2-р сургууль 24-р цэцэрлэг

65	2.2.8	СЗДУАХ-ийн 2.2.9	Сургууль, цэцэрлэгийн зөвлөлийн үйл ажиллагаагаар дамжуулан сургууль, эцэг эхийн хамтын ажиллагааг сайжруулна.	Сургууль, цэцэрлэгийн зөвлөлийн үйл ажиллагаа тогтмолжоогүй.	Хүүхдийн хөгжил, төлөвшилд эерэг нөлөө үзүүлнэ	Орон нутгийн төсвөөс	Жилдээ	Нийгмийн бодлого хариуцсан мэргэжилтэн
66	2.2.9	СЗДУАХ-ийн 2.2.12	Хүүхэд, Залуучуудын чуулга уулзалт зохион байгуулна.	Залуучуудын чуулга уулзалт 1 удаа зохион байгуулагдаж дахин зохион байгуулаагүй байна.	Хүүхдэд тулгамдаж байгаа асуудлыг сонсч эцэг, эх, сургуулийн хамтын ажиллагаа сайжирна.	Орон нутгийн төсвөөс	1-р улиралд	Хүүхэд хөгжлийн төв, Нийгмийн бодлого хариуцсан мэргэжилтэн
67	2.2.10	СЗДУАХ-ийн 2.2.14	Хүүхэд хөгжлийн төвийн үйл ажиллагааг тогтмолжуулна.	Хүүхэд хөгжлийн төвийн үйл ажиллагааг эхлүүлэхээр 5,0 сая төгрөгийг орон нутгаас шийдвэрлэж өгсөн байна.	Хүүхэд хөгжлийн төвийн үйл ажиллагаа тогтмолжиж хүүхэд залуучуудын хөгжих боломж нөхцөл сайжирна.	Аймгийн Гэр бүл хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас	Жилдээ	Сумын Засаг дарга, Хүүхэд хөгжлийн төвийн эрхлэгч
68	2.2.11	СЗДУАХ-ийн 2.2.11	Оюутны тэтгэлэгт" хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.	Жил бүр 5 оюутанд 500,000 төгрөгийн тэтгэлэг олгодог.	Оюутнуудад санхүүгийн дэмжлэг үзүүлж, сайн суралцах хөшүүрэг бий болно.	Засаг даргын нөөц хөрөнгөөс	Жилдээ	Нийгмийн бодлого хариуцсан мэргэжилтэн

2.3. Биеийн тамир, спорт, соёл урлагийн чиглэлээр:

Үндэсний өв соёлыг хөгжүүлэх, сурталчилах, соёлын үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулан, нийтийн биеийн тамир, спортыг нийт иргэдийн хүртээл болгох, тэднийг хөдөлгөөний хомсдолоос урьдчилан сэргийлэх бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.

Нийтийн биеийн тамир, спортын чиглэлээр:

69	2.3.1	СЗДУАХ-ийн 2.3.1	Сумын Засаг даргын нэрэмжит "Спортын олон төрөлт тэмцээн"-ийг жил бүр зохион байгуулна.	Жил бүр спортын 5 төрлөөр уламжлал болон зохион байгуулан явуулдаг.	Нийтийн биеийн тамир спортыг сурталчилан иргэдийг хөдөлгөөний хомсдлоос урьдчилан сэргийлж бие бялдрыг сайжруулна	Засаг даргын нөөц хөрөнгөөс	Жилдээ	Нийгмийн бодлого хариуцсан мэргэжилтэн
70	2.3.2	СЗДУАХ-ийн 2.3.4	Үндэсний спортуудын холбоодын үйл ажиллагааг дэмжиж ажиллана.	Үндэсний спортын холбоод байргүйгээс тогтмол үйл ажиллагаа явуулж чаддаггүй байна.	Спортын төрөлжсөн холбоодын үйл ажиллагаа тогтмолжиж хичээллэх хүүхэд залуучуудын тоо нэмэгдэнэ.	Нийгмийн хариуцлагын гэрээгээр	Жилдээ	Нийгмийн бодлого хариуцсан мэргэжилтэн

Соёл урлагийн чиглэлээр:

71	2.3.3	СЗДУАХ-ийн 2.3.5	Сумын Нийтийн номын сангийн фонд баяжилтыг нэмэгдүүлж алслагдсан малчин өрхүүдэд соёл урлагийн явуулын үйлчилгээг жилд 2-оос доошгүй удаа зохион байгуулна.	3800 нэр төрлийн номын фонд номийн сан үйл ажиллагаагаа явуулж байна.	Фонд баяжилт хийгдсэнээр уншигч ирэгсдийн тоо нэмэгдэнэ.	Яамны хөрөнгө оруулалтаар	Жилдээ	Соёлын төв
72	2.3.4	СЗДУАХ-ийн 2.3.8	Угийн бичиг хөтөлдөг өрхийн тоог нэмэгдүүлнэ.	Сумын хэмжээнд угийн бичиг хөтлөлт хангалтгүй хэрэгжиж байна.	Өрх бүр угийн бичиг хөтлөлт сайжирч, сумын хэмжээнд 40%-д хүрсэн байна.	Соёлын төвийн төсвөөс	Жилдээ	Соёлын төв
73	2.3.5	СЗДУАХ-ийн 2.3.6	Соёлын төвийн урлагийн хувцасны хангамжийг сайжруулж, орон нутаг судлах танхимд үзмэрийн тоог нэмэгдүүлж иргэдэд сурталчилна.	Орон нутаг судлах танхим байгуулах өрөө тасалгаа байхгүйгээс өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан тасалгаа гарган тавиур хийж үзмэрүүдээ байрлуулсан.	Сум орон нутгийн өв соёлын бүртгэлтэй болох иргэдэд үйлчлэх үзмэрийн тоо нэмэгдэнэ.	Соёлын төвийн төсвөөс	Жилдээ	Соёлын төв
74	2.3.6	СЗДУАХ-ийн 2.3.9	Сумын Түүх соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийг бүртгэх, хамгаалах талаар олон талт ажлыг иргэдтэй хамтран зохион байгуулна.	Түүх соёлын үл хөдлөх дурсгалт зүйл 220 гариу зүйлс бүртгэгдсэн байна.	Үл хөдлөх дурсгалт зүйлийн бүрэн бүтэн байдалд хяналттай болно.	Соёлын төвийн төсвөөс	Жилдээ	Соёлын төв
75	2.3.7	СЗДУАХ-ийн 2.3.7	Соёлын төвийн үйл ажиллагааг дүрсжүүлэх, соёлын биет өв биет бус өвийг бүртгэх хадгалах хамгаалахад шаардагдах болон төр, төсвийн байгууллагуудын гадна орчныг камержуулахад шаардагдах төсвийн асуудлыг шийдвэрлэнэ.	Дүрсжүүлж хадгалсан үйл ажиллагаа байхгүй. Мөн гадна талдаа камержуулалт хийсэн төр, төсвийн байгууллага байхгүй.	Соёлын өвийг дүрсжүүлэн хадгалах боломжтой болно.	Соёлын төв болон байгууллагууд өөрсдийн төсвөөс	Жилдээ	Соёлын төв

2.4.Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын чиглэлээр:

Өрх бүрээс нэг иргэн ажилтай орлоготой байх бодлого барьж, Баялаг бүтээгчдийг дэмжин ажлын байр бий болгон өрхийн орлогыг нэмэгдүүлэн ажилгүй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.

76	2.4.1	СЗДҮАХ-ийн 2.4.3	Айл өрх бүрээс 1-ээс доошгүй иргэнийг тогтмол ажлын байранд зуучлан хөдөлмөр эрхлэлтийн шинэ бодлого хэрэгжүүлнэ.	Энэ онд 60 шинэ ажлын байр бий болгох зорилттой. 9-р сарын байдлаар 32 шинэ ажлын байр бий болгож 53,3%-тай байна.	Нэг өрх-нэг ажлын байр бодлого хэрэгжинэ.	-	Жилдээ	Хөдөмөр эрхлэлт хариуцсан мэргэжилтэн
77	2.4.2	СЗДҮАХ-ийн 2.4.3	Суманд үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага, аж ахуй нэгжүүдийг Хөдөлмөр эрхлэлтийн албаар дамжуулан орон нутгаас ажиллах хүчээ авах ажилгүй иргэдийг ажлын байранд тэнцэх сургалтанд хамруулах замаар ажилгүйдлийг бууруулна.	Сумын хөдөлмөр эрхлэлт хариуцсан мэргэжилтэнд ажлын байрны захиалга өгөх, ажил идэвхтэй хайгч иргэдээс сонгож ажилд авах байдал төр, хувийн хэвшлийн аль ч байгууллагуудад хангалтгүй байдаг.	Нэг өрх-нэг ажлын байр бодлого хэрэгжинэ.	-	Жилдээ	Хөдөлмөр эрхлэлт хариуцсан мэргэжилтэн
78	2.4.3	СЗДҮАХ-ийн 2.4.5	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.	Төр, хувийн хэвшил, хувиараа нийт 15 хөгжлийн бэрхшээлтэй иргэн хөдөлмөр эрхэлдэг байна.	Иргэдийн орлого нэмэгдэж, нийгмийн амьдралд оролцох идэвхи нэмэгдэнэ.	Хөдөлмөр эрхлэлтийн төсөл хөтөлбөр болон бусад эх үүсвэрээр	Жилдээ	Хөдөмөр эрхлэлт хариуцсан мэргэжилтэн
79	2.4.4	СЗДҮАХ-ийн 2.4.9	Харьцангуй бага орлоготой айл өрхийг түслэх аж ахуй эрхлүүлэх замаар ажлын байр, амьжиргааны эх үүсвэртэй болгоно.	Суманд өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгаар амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой 25 өрх байгаагаас энэ онд 6-г нь төсөл хөтөлбөрт хамруулсан байна.	Өрхийн орлого амьжиргааны эх үүсвэртэй болно.	Хөдөлмөр эрхлэлтийн төсөл хөтөлбөрөөр	Жилдээ	Хөдөмөр эрхлэлт хариуцсан мэргэжилтэн
80	2.4.5	СЗДҮАХ-ийн 2.4.2	Суманд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг дэмжиж ажиллана.	Сумы Ахмадын хороодоос өөр тогтвортой үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага байхгүй.	Төрийн бус байгууллага, төрийн байгууллагын хамтын ажиллагаа сайжирч иргэд үр ашгийг нь хүртэнэ.	Орон нутгийн төсвөөс	Жилдээ	ЗДТГ-н дарга
81	2.4.6	СЗДҮАХ-ийн 2.4.17	“Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орчныг сайжруулах” сумын дэд	Хөдөлмөрийн Аюулгүй Байдал Эрүүл ахуйн тухай зааварчилгааг хангалтгүй өгдөг.	ХАБЭА сургалтуудыг үе шаттайгаар зохион байгуулж улиралд 15 доошгүй ААН	Орон нутгийн төсвөөс	Жилдээ	Хөдөлмөр эрхлэлт хариуцсан мэргэжилтэн

			хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллана.		байгууллагаар явж хяналт шалгалтыг тогтмолжуулна			
82	2.4.7	СЗДУАХ-ийн 2.4.1	Сумын ИТХ-аар баталсан “Ахмад настанд хөнгөлөлт тусламж үзүүлэх журам”-ыг сайжруулж сумын ИТХ-н хуралд санал оруулж үргэлжлүүлэх асуудлыг зохион байгуулна.	Төсвөөс шалтгаалан ахмад настануудын нийгмийн хамгааллын хүрээнд томоохон ажил арга хэмжээ зохион байгуулах боломжгүй.	Ахмад настануудын нийгмийн хамгааллын асуудлыг шийдвэрлэхэд ахиц гарна.	Засаг даргын нөөц хөрөнгөөс	Жилдээ	Халамжийн мэргэжилтэн
83	2.4.8	СЗДУАХ-ийн 2.4.7	70-аас дээш настай ахмад настануудыг ЭМТ-үүдтэй хамтран эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт улиралд 1 удаа хамруулах ажлыг тогтмолжуулна.	Алслагдсан өрхийн ахмадууд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт улирал тутам орж чадахгүй байна.	Өвчлөлөөс урьдчилан сэргийлж, эрт илрүүлнэ.	Эрүүл мэндийн төвүүдийн төсвөөс	Жилдээ	Эрүүл мэндийн төвүүд
84	2.4.9	СЗДУАХ-ийн 2.4.12	“Шинэ төрсөн хүүхэд эхчүүдэд хүндэтгэл үзүүлэх журам”-г үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.	Жилд 65-85 орчим хүүхэд шинээр мэндэлж байна.	Төрөлтийг дэмжихэд эерэг нөлөө үзүүлнэ.	Засаг даргын нөөц хөрөнгөөс	Жилдээ	Улсын бүртгэгчид
85	2.4.10	СЗДУАХ-ийн 2.4.13	Сумын төв болон Рашаант тосгоны орон сууцнуудад СӨХ байгуулж байнгын ажиллагаатай болгох ажлыг иргэдтэй хамтран шийдвэрлэнэ.	Сумын төвийн орон сууцнуудыг хариуцсан СӨХ байхгүй.	СӨХ байгуулагдсанаар 1-2 ажлын байр нэмэгдэж орон сууцны оршин суугчдад тулгардаг тохижилт, цэвэрлэгээ үйлчилгээний асуудал шийдвэрлэгдэнэ.	-	Жилдээ	Засаг даргын орлогч
86	2.4.11	СЗДУАХ-ийн 3.2.6	Улсын бүртгэлийн ажил үйлчилгээний шуурхай байдлыг хангаж, бүртгэлийн үйлчилгээг чирэгдэлгүй хүргэх боломж нөхцөлийг бүрдүүлнэ.	Иргэдийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэх байдал хангалтгүй байна.	Бүртгэлийн үйлчилгээний чанар, хүртээмж сайжирна.	-	Жилдээ	Улсын бүртгэгчид Газрын даамал
87	2.4.12	СЗДУАХ-ийн 2.4.10	Нийгмийн даатгалын сайн дурын даатгалд ажилгүй иргэн, малчин, бичил	Сайн дураар эрүүл мэнд, нийгмийн даатгалд хамрагдах иргэдийн идэвх сул байна.	Аймаг, сумын ЗД-н гэрээний биелэлт хангагдана.	-	Жилдээ	Нийгмийн даатгалын байцаагч

			үүрхай эрхлэгчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг хамруулна.					
88	2.4.13	СЗДҮАХ-ийн 2.4.18	Эрүүл мэндийн заавал даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлнэ.	Хувийн хэвшлийн байгууллагууд нь ажиллагсадаа нэн ялангуяа улирлын чанартай ажилчдыг эрүүл мэндийн даатгалд хамруулдаггүй.	Аймаг, сумын ЗД-н гэрээний биелэлт хангагдана.	-	Жилдээ	Нийгмийн даатгалын байцаагч

ГУРАВ. ТӨРИЙН ЗАХИРГАА, ХУУЛЬ ХЯНАЛТЫН БОДЛОГО

3.1.Төрийн захиргааны чиглэлээр:

Төрийн үйлчилгээг иргэдэд хөнгөн шуурхай хүргэн үйлчилгээний ил тод байдлыг ханган, төрөөс гарах шийдвэрт иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.

89	3.1.1	СЗДҮАХ-ийн 3.1.1	Сумын Засаг даргын Тамгын газарт Чанарын удирдлагын тогтолцооны ISO 9001:2015 стандартыг нэвтрүүлж, Үндэсний чанарын хөтөлбөрийг хэрэгжүүлэгч байгууллага болох зорилт тавьж ажиллана.	Бичиг баримтын эмх цэгц сайжирч ажлын бүтээмж дээшилсэн.	Иргэдэд хүрэх төрийн үйлчилгээг олон улсын стандартад нийцүүлэхэд шат ахисан байна.	Нийгмийн хариуцлагын гэрээгээр	Жилдээ	ЗДТГ-н дарга
90	3.1.2	СЗДҮАХ-ийн 3.1.2	Төрийн албаны сахилга, хариуцлагыг өндөржүүлж иргэдийн санал, хүсэлтэд тулгуурлан үйлчилгээний чанар, хүртээмжийг улам бүр сайжруулж, төрийн албан хаагчдын үйл ажиллагааг олон нийтээр үнэлүүлж, үр дүнг тооцох	Үнэлгээ авах байдлыг боловсронгуй болгох шаардлагатай.	Төрийн албан хаагчдын ажлыг бодитойгоор үнэлж шагнал урамшил, сахилга хариуцлагыг оновчтой болгоно.	Байгууллагууд өөрсдийн нөөц бололцоогоор	Улирал тутам	Төсвийн шууд захирагч нар
91	3.1.3	СЗДҮАХ-ийн	Төрийн албан хаагчийн сургалт, солилцоо, Нийгмийн баталгаа хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангана.	Төрийн албан хаагчид ажлаасаа хөндийрөлгүй сурах боломж бололцоо сул байна.	Төрийн албан хаагчдийн мэдлэг чадвар дээшилж нийгмийн асуудал нь шийдвэрлэгдэнэ.	Байгууллагууд өөрсдийн нөөц бололцоогоор	Жилдээ	Төсвийн шууд захирагч нар

92	3.1.4	СЗДҮАХ-ийн 3.2.3	Архивын баримт бичгийн хөтлөлт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах үзлэг шалгалтыг жил бүр зохион байгуулна.	Сумын болон байгууллагуудын архивын өрөө, тавиурын тоо хангалтгүй.	Архивын өрөөг стандартын дагуу тохижуулж баримтын хадгалалт сайжирна.	Байгууллагын төсвөөс	Жилдээ	Төсвийн шууд захирагч нар
93	3.1.5	СЗДҮАХ-ийн 3.1.3	Сум, тосгоны албан ёсны цахим хуудсыг шинэчлэн мэдээллийн баяжилтыг тогтмолжуулж, иргэдийг орон нутгийн мэдээ мэдээллээр шуурхай хангана.	Сумын цахим хуудасны баяжилт, мэдээлэл дутмаг байна	Мэдээллийн ил тод, шуурхай байдал хангагдана.	-	Жилдээ	Мэдээллийн ажилтан
94	3.1.6		Улаанбаатар болон томоохон хотууд дахь Нутгийн зөвлөлүүдийн бүрэлдэхүүнийг шинэчилж, үйл ажиллагааг нь идэвхжүүлнэ.	Нутгийн зөвлөлүүдийн үйл ажиллагаа тогтмолжиж идэвхжээгүй байна.	Нутгийн зөвлөлүүдийн үйл ажиллагааг тогтмолжуулж, байнгын үйл ажиллагаатай болсон байна.	Нийгмийн хариуцлагын гэрээгээр	Жилдээ	Засаг дарга, Орлогч дарга, ЗДТГ-ын дарга

3.2.Хууль хяналтын чиглэлээр:

Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, хуулийн хэрэгжилтийг чанд мөрдүүлэх замаар гэмт хэргийн гаралтыг бууруулан иргэдийн аюулгүй амьдрах орчин нөхцөлийг сайжруулна.

95	3.2.1	СЗДҮАХ-ийн 3.1.13	Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлж нээлттэй утсаар мэдээлэл авч холбогдох байгууллагуудад тавьж шийдвэрлүүлж хариу өгч ажиллана.	Хүнсний хадгалах хугацаа, үнэ, эрүүл ахуйн талаар иргэд санал гомдолтой байдаг.	Хэрэглэгчдийн эрх ашиг хамгаалагдаж хуулийн хэрэгжилт хангагдана.	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас	Жилдээ	Хэрэглэгчийн эрхийг хамгаалах орон тооны бус
96	3.2.2	СЗДҮАХ-ийн 3.2.1	Архи согтууруулах ундаа худалдах цэгийн тоо, согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн тоог бууруулна.	Өнгөрсөн 2017 онд согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 7 гарсан байгаа нь 2016 оноос 2-оор буурсан үзүүлэлттэй байна.	Худалдах цэгийн тоо буурч согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн тоо буурна.	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас	Жилдээ	Цагдаагийн алба 1,2-р багийн Засаг дарга нар
97	3.2.3	СЗДҮАХ-ийн 3.2.2	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, хүүхэд, гэр	Сумын ЗДТГ болон байгууллагууд жилд 10-15 удаа сургалт зохион байгуулж	Иргэдийн эрх зүйн мэдлэг дээшилж гэмт хэргийн гаралт буурна. Гэр бүл, хүүхдийн	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас	Жилдээ	Хүүхэд хөгжлийн төв, Хамтарсан баг,

			бүлийг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгааны ажлыг мэргэжлийн байгууллагын тусламжтайгаар жилд 1-ээс доошгүй удаа сургалт зохион байгуулна.	давхардсан тоогоор 2300-3500 иргэнийг хамруулдаг.	хүчирхийллийн гаралт 50%-иар буурна.			ТЗ,ХЭЗ-н мэргэжилтэн, Багийн Засаг дарга нар
98	3.2.4	СЗДҮАХ-ийн 3.2.5	Авлигатай тэмцэх, хариуцлага, шударга ёсыг бэхжүүлэх, авлига ашиг сонирхлын зөрчилгүй байгууллага хамт олон байх хөдөлгөөн өрнүүлнэ.	Энэ онд Ёс зүйн зөрчилгүй байгууллага хамт олон аян зохион байгуулан ажилласан бөгөөд авлига ашиг сонирхлын зөрчил гарсан талаар иргэдээс санал гомдол гараагүй байна.	Төрийн албан хаагчдын хариуцлга, ёс зүй дээшилж соён гэгээрүүлэх ажил зохион байгуулагдаж авлига ашиг сонирхлын зөрчил гарахгүй.	Байгууллагууд өөрсдийн хөрөнгөөр	Жилдээ	Төсвийн шууд захирагч нар

_____оОо_____